



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ЭХНИЙ V САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ
2019.06.16

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ЭХНИЙ V САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

II. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум төгрөгийг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний V сарын байдлаар улсын төсөвт **1.2** их наяд төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **15.8** тэрбум төгрөг,
- Нүүрс **523.3** тэрбум төгрөг,
- Цайр **41.4** тэрбум төгрөг,
- Зэс **531.0** тэрбум төгрөг,
- Төмөр **9.8** тэрбум төгрөг,
- Жонш **13.5** тэрбум төгрөг,
- Бусад **25.3** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **308.4** тэрбум төгрөг буюу **36.2** хувиар өссөн байна. Үүнд:

- Нүүрс **205.1 (64.4%)** тэрбум төгрөг,
- Зэс **105.9 (24.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **1.2 (14.4%)** тэрбум төгрөг,
- Жонш **7.1 (110.6%)** тэрбум төгрөг,

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Алт **5.0 (24.1%)** тэрбум төгрөг,
- Цайр **2.1 (4.8%)** тэрбум төгрөг,
- Бусад АМ **3.8 (13.1%)** тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018		2019		Өөрчлөлт			
	V	I-V	V	I-V	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	157.0	851.8	189.0	1,170.0	32.1	20.4%	318.2	37.4%
Алт	9.3	20.8	2.8	15.8	-6.5	-70.0%	-5.0	-24.1%
Нүүрс	62.4	318.2	75.1	523.3	12.7	20.3%	205.1	64.4%
Цайр	5.8	43.4	7.9	41.4	2.1	36.2%	-2.1	-4.8%
Зэс	73.2	425.2	83.1	531.0	9.8	13.4%	105.9	24.9%
Төмөр	0.3	8.6	3.2	9.8	2.8	9.2 ¹	1.2	14.4%
Жонш	1.8	6.4	3.8	13.5	2.0	2.1 ¹	7.1	2.1 ¹
Бусад	4.1	29.1	3.4	25.3	-0.7	-17.9	-3.8	-13.1%

Тайлбар: 1 – дахин их

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 оны эхний V сард **21.2** сая тн нүүрс, **589.9** мян.тн зэсийн баяжмал, **3.8** тн алт, **2.1** мян.тн молибдений баяжмал, **54.0** мян.тн хайлуур жоншны хүдэр, **13.6** мян.тн хайлуур жоншны баяжмал, **2.8** сая тн төмрийн хүдэр, **1.2** сая тн төмрийн хүдрийн баяжмал, **38.1** мян.тн цайрын баяжмал, **2.8** сая тн бар газрын тос үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **2.1** сая тн буюу **10.8** хувь, зэсийн баяжмал **44.2** мян.тн буюу **8.1** хувь, төмрийн хүдэр **698.7** мян.тн буюу **32.9** хувь, төмрийн хүдрийн баяжмал **12.8** мян.тн буюу **1.1** хувь, хайлуур жоншны хүдэр **5.6** мян.тн буюу **11.6** хувь, цайрын баяжмал **1.9** мян.тн буюу **5.2** хувиар ихээр тус тус өссөн байна.

Харин алт **953.1** кг буюу **20.0** хувь, молибдены баяжмал **6.8** тн буюу **0.3** хувь, хайлуур жоншны баяжмал **9.0** мян.тн буюу **39.8** хувь, газрын тос **52.5** мян.бар буюу **1.8** хувь, катодын зэс **627.5** тн буюу **10.4** хувиар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт			
			V	I-V	V	I-V	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	4,361.4	19,134.7	4,421.5	21,208.3	60.1	1.4%	2,073.6	10.8%
1.2	Газрын тос	мян.бар	556.9	2,838.0	564.9	2,785.5	8.0	1.4%	-52.5	-1.8%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	106.6	545.7	116.6	589.9	10.0	9.4%	44.2	8.1%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	415.1	2,144.8	393.0	2,138.0	-22.1	-5.3%	-6.8	-0.3%
1.5	Алт	кг	1,871.0	4,759.3	1,494.7	3,806.2	-376.3	-20.1%	-953.1	-20.0%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдэр	мян.тн	521.0	2,122.6	750.2	2,821.3	229.2	44.0%	698.7	32.9%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	185.1	1,206.0	182.8	1,218.8	(2.3)	-1.2%	12.8	1.1%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	10.4	48.4	13.8	54.0	3.4	32.7%	5.6	11.6%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	1.3	22.6	10.2	13.6	8.9	684.6%	-9.0	-39.8%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	6.2	36.2	6.4	38.1	0.2	3.2%	1.9	5.2%
2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Катодын зэс, 99%	тн	1,264.2	6,032.0	1,076.5	5,404.5	-187.7	-14.8%	-627.5	-10.4%
2.2	Металл бэлдэц	тн	591.4	12,212.4	3,663.9	13,520.4	3,072.5	519.5%	1,308.0	10.7%
2.3	Металл цувимал	тн	2,000.0	12,793.2	4,096.0	13,357.0	2,096.0	104.8%	563.8	4.4%

Эх сурвалж: УСХ

II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	V	I-V	V	I-V	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,486.6	5,987.3	1,632.5	6,929.6	146.0	9.8%	942.3	15.7%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,077.9	4,297.4	1,127.6	5,015.5	49.6	4.6%	718.1	16.7%
Нүүрс олборлолт	448.1	1,574.5	506.4	2,194.5	58.3	13.0%	620.0	39.4%
Газрын тос олборлолт	92.6	437.7	90.5	420.2	-2.1	-2.3%	-17.5	-4.0%
Металлын хүдэр олборлолт	528.1	2,235.8	516.1	2,352.6	-12.0	-2.3%	116.8	5.2%
Бусад ашигт малтмал олборлолт	9.1	49.4	14.5	48.2	5.5	60.5%	-1.2	-2.4%
Боловсруулах аж үйлдвэр	330.1	1,212.6	416.2	1,388.9	86.2	26.1%	176.3	14.5%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний V сард **6.9** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **942.3 (15.7%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **5.0** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **718.1 (16.7%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **620.0 (39.4%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **116.8 (5.2%)** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.4** хувийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019			Өөрчлөлт			
	V	I-V	V	I-V	Гад-дад	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,615.8	6,904.3	1,859.3	8,292.3	6,078.6	243.4	15.1%	1,388.0	20.1%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,082.3	4,825.5	1,206.7	5,779.1	5,153.2	124.4	11.5%	953.6	19.8%
Нүүрс олборлолт	354.4	1,726.6	430.3	2,241.2	2,028.0	75.9	21.4%	514.5	29.8%
Газрын тос олборлолт	92.4	427.2	83.6	396.0	396.0	-8.7	-9.5%	-31.1	-7.3%
Металлын хүдэр олборлолт	623.8	2,616.0	672.9	3,065.7	2,684.2	49.1	7.9%	449.8	17.2%
Бусад ашигт малтмал олборлолт	11.7	55.8	19.8	76.2	44.9	8.2	69.9%	8.2	36.6%
Боловсруулах аж үйлдвэр	454.9	1,598.6	563.5	1,985.3	925.4	108.6	23.9%	386.7	24.2%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний V сард **8.3** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.4 (20.1%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **5.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **953.6 (19.8%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **514.5 (29.8%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **449.8 (17.2%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **6.1 (73.3%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **5.2 (62.1%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний V сарын гүйцэтгэлээр **5.6** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **514.5 (10.2%)** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **948.3** сая ам.доллараар эерэг гарсан байна.

III.1. ЭКСПОРТ

Экспорт 3.3 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **378.2 (13.2%)** сая ам.доллараар өссөн байна. Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.6%** буюу нийт экспортын **83.1** хувийг эзлэж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-V		2019 I-V		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн/сая \$	14.1	1,103.6	15.1	1,271.5	0.9	6.7%	168.0	15.2%
2	Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	601.0	823.3	624.3	893.1	23.3	3.9%	69.8	8.5%
3	Боловсруулаагүй нефть	сая бар/сая \$	2.8	177.2	2.6	150.1	-0.14	-5.0%	-27.1	-15.3%
4	Төмрийн хүдэр, баяжмал	сая тн/сая \$	2.8	131.2	3.5	207.5	0.7	26.0%	76.2	58.1%
5	Хайлуур жонш	мян.тн/сая \$	153.4	50.6	221.5	74.8	68.1	44.4%	24.2	47.9%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	52.3	92.8	64.8	95.8	12.6	24.1%	3.0	3.3%
7	Молибдений хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	2.3	18.3	2.3	20.3	-0.01	-0.5%	2.0	10.8%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	7.7	19.9	9.5	21.3	1.7	22.4%	1.5	7.3%
9	Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн/сая \$	25.1	0.3	39.1	0.6	14.0	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдын хүдэр, баяжмал	тн/сая \$	127.9	1.7	163.0	1.7	35.1	27.5%	0.0	0.6%
11	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн/сая \$	3.4	144.5	4.7	195.9	1.2	35.9%	51.4	35.6%

Эх сурвалж: ГЕГ

Чулуун нүүрс экспорт 2019 оны эхний V сард **1,271.5** сая ам.долларын **15.1** сая тн нүүрс экспортолсоныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр **168.0** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **946.9** мян.тн-оор тус тус их байна. 2018 оны мөн үед 1 тн нүүрсний хилийн дундаж үнэ **78.2** ам.доллар байсан бол 2019 онд **84.4** ам.доллар болж өсчээ. Чулуун нүүрсний **98.1 %** БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний V сард **624.3** мян.тн-ыг экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **23.3** мян.тн-оор их байгаа ба хилийн дундаж үнэ **1,369.8** ам.доллараас **1,430.4** ам.доллар болж **60.6** ам.доллараар өссөн байна. 2018 оны эхний V сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **823.3** сая ам.доллар байсан бол тайлант сард **893.1** сая ам.доллар болсон.

Боловсруулаагүй нефтийн экспорт **2,627.7** мян.бар буюу **150.1** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **137.9** мян.бар-иар, үнийн дүнгээр **27.1** сая ам.доллараар тус тус бага байна. 1 баррель нефтийн хилийн дундаж үнэ **64.1** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **57.1** ам.доллар болж буурчээ.

Төмрийн хүдрийн экспорт **3,489.2** мян.тн буюу **207.5** сая ам.долларт хүрсэн байна. 2018 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **720.9** мян.тн-оор, үнийн дүн нь **76.2** сая ам.доллараар тус тус өсчээ. 1 тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **59.5** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **12.1** ам.доллараар өссөн байна.

Цайрын баяжмал экспорт 2019 оны эхний V сард **64.8** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дунджаар **1,478.1** ам.доллараар экспортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **297.7** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **95.8** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **3.0** сая ам.доллараар нэмэгджээ.

Хайлуур жоншны экспорт 2019 оны эхний V сард **74.8** сая ам.долларын **221.5** мян.тн жонш экспортлосон нь 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **68.1** мян.тн-оор, үнийн дүнгээр **24.2** сая ам.доллараар тус тус өссөн байна. Хайлуур жоншны экспортын дундаж үнэ **337.9** ам.доллар болж,

өнгөрсөн оны мөн үеийнхээс **8.0** ам.доллараар өссөн байна. Хайлуур жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортлосон ба 34.8% нь ОХУ-д, 64.7% нь БНХАУ-д тус тус ногдож байна.

Молибдены баяжмалын экспорт үнийн дүнгээр **20.3** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **2.0** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний 1 тн-ны экспортын хилийн дундаж үнэ **7,864.4** ам.доллараас **8,760.3** ам.долларт хүрч, **895.9** ам.доллараар өсчээ. 2019 оны эхний V сард **2,321.0** тн-ыг экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеэс **11.9** тн-оор бага байна. Молибдений баяжмалын 76.1 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Алтны экспорт 2019 оны эхний V сард **4,665.2** кг алт экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **1,233.3** кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед **42,104.9** ам.доллар байсан бол 2019 онд **41,998.0** ам.доллар болж **106.9** ам.доллараар багассан байна. Алтны экспорт үнийн дүнгээр **195.9** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **51.4** сая ам.доллараар өссөн байна.

III.2. ИМПОРТ

Импорт **2.3** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **136.3 (6.3%)** сая ам.доллараар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **505.6** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **36.8** сая ам.доллараар буюу **7.8** хувиар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.2** хувийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. 2019 оны эхний V сард **425.7** сая ам.долларын **680.2** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **102.3** мян.тн-оор, үнийн дүнгээр **40.1** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **91.8** хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний **35.0** хувийг автобензин, **65.0** хувийг дизель түлшний импорт эзлэж байна.

Автобензины импорт **218.6** мян.тн автобензин болж 2018 оны мөн үеийн дүнгээс **74.5** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **676.0** ам.доллар байсан бол 2019 онд **576.8** ам.доллар болж **14.7** хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт **406.1** мян.тн болж 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **83.6** мян.тн-оор өссөн байна. 2018 оны эхний V сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **641.4** ам.доллар байсан бол 2019 онд **622.8** ам.долларт хүрч **18.6** ам.доллар буюу **2.9** хувиар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **46.1** сая ам.доллараар нэмэгдсэн байна.